



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 03 өдөр

Дугаар А/190

Арвайхээр

Ажлын хэсэг байгуулах тухай

Автотээврийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.9, 6.1.12, Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4, Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын хуулийн 6 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн хуралдааны 47 дугаар тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын цахим гэрчилгээг суурилуулах, хяналт тавих ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: И.Доржсүрэн (аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүд:

Н.Эрдэнэсүвд (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Татварын хэлтсийн дарга)

Ц.Алтан-Эрдэнэ (аймгийн Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн дарга)

Б.Цэндсүрэн (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Автотээврийн хяналтын улсын байцаагч)

Нарийн бичгийн дарга: Д.Амартүвшин (аймгийн Автотээврийн төвийн дарга)

2.Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын цахим гэрчилгээг суурилуулах ажлыг сайтар зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (И.Доржсүрэн)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0346

D:My Doc. Zahiramj. Zasag darga